

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

ИРГЭНД ХИШИГ, ХУВЬ ХҮРТЭЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

2010 оны 1 дүгээр сарын 6-ны одор Улаанбаатар хот Дугаар 3

Хvний хогжил сангийн тухай хуулийн 15.1, 15.3, 17.4, Улсын Их Хурлын 2009 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар зvйлийн 3 дахь заалтыг vндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хvний хогжил сангаас хоронго зарцуулах журам"-ыг 1 дvгээр, "Монгол Улсын иргэн хишиг, хувь хvртэх журам"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталж, "Хvний хогжил сан" дэвтрийн загварыг 3 дугаар хавсралт ёсоор зовшоорсвгэй.

2. Иргэний бvртгэлийн тухай хууль тогтоомжийн зорчилгvй иргэнд Хvний хогжил сангаас хишиг, хувь ve шаттай хvртээх ажлыг 2010 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн зохион байгуулахыг Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд Т.Гандид даалгасугай.

3. 2010 онд иргэнд олгох хишиг, хувийг 2 хуваан олгож, vннээс эхний ээлжинд 70.0 (далан) мянган тогрогийг 2010 оны 2 дугаар сарын 1-ний одроос эхлэн олгоход шаардагдах хоронгийг тухай бvрт нь санхvvжvвлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

4. Дараахь арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд Т.Ганди нарт даалгасугай:

а) иргэний шинэчилсэн бvртгэл явуулах вйл ажиллагааны нэмэлт зардалд 1,773.0 (нэг тэрбум долоон зуун далан гурван сая) сая тогрог, Хvний хогжил сангаас иргэнд хишиг, хувь хvртээх бэлтгэл ажлыг хангах вйл ажиллагааны зардалд 236.0 (хоёр зуун гучин зургаан сая) сая тогрогийг тус тус Засгийн газрын нооц сангаас гаргаж, цаашид Монгол Улсын 2010 оны тосвийн тухай хуульд нэмэлт, оорчлолт оруулж батлуулах;

б) иргэн бvрт олгох "Хvний хогжил сан" дэвтэр болон маягт хэвлvvлэх зардалд зориулан 1,150.0 (нэг тэрбум нэг зуун тавин сая) сая тогрогийг эргэн тологдох нохцолтэйгээр улсын тосвоос санхvvжvвлж дэвтрийн vнийг иргэдээс хураан авч улсын тосовт товлорvvлэх.

5. "Хvний хогжил сан" дэвтрийн vнэ болон нийлvvлэх хугацааг харгалзан дэвтэр, маягт хэвлэх ажлын гvйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулахыг Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд Т.Гандид зовшоорсвгэй.

6. Улсын Их Хурлын 2009 оны 100 дугаар тогтоолд заасны дагуу иргэний шинэчилсэн бvртгэлийг 2010 оны 10 дугаар сард багтаан явуулах зорилгоор шинэчилсэн бvртгэл явуулах бэлтгэлийг хангах зовлох вйлчилгээ, программ хангамж, тоног тохооромж нийлvvлэх гvйцэтгэгчийг шууд гэрээ байгуулах аргаар сонгон шалгаруулахыг Улсын бvртгэлийн еронхий газрын дарга Л.Монхбаатарт зовшоорсвгэй.

7. Иргэнд хишиг, хувь хvртээхтэй холбогдуулан иргэний шинэчилсэн бvртгэлийг 2010

онд явуулах арга хэмжээ авахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуягт, цаашид шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэдийн талаар мэдээлэлд орсон оорчлолтийг сар бүр Ходолмор, халамжийн үйлчилгээний газарт хвргүүлж байхыг Улсын бүртгэлийн еронхий газрын дарга Л.Монхбаатарт, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдсан иргэнд хишиг, хувийг 2010 онд багтаан хүртээж дуусгахыг Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд Т.Ганди нарт тус тус үүрэг болгосугай.

8. Иргэний шинэчилсэн бүртгэлд Монгол Улсын иргэнийг бүртгэх, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлыг зохион байгуулахад улсын бүртгэл болон нийгмийн халамжийн байгууллагад бүх талын дэмжлэг үзүүлж, бүрэн эрхийнхээ хүрээнд шаардлагатай хүний нооц, хоронго гарган ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

9. Иргэний шинэчилсэн бүртгэлд Монгол Улсын иргэнийг бүртгэх, Хүний хөгжил сангаас иргэнд хишиг, хувь хүртээх ажлын дүнг 2011 оны 2 дугаар сарын 1-ний дотор Засгийн газарт танилцуулахыг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд Т.Ганди нарт даалгасугай.

Монгол Улсын Еронхий сайд

С.БАТБОЛД

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга

Ч.ХҮРЭЛБААТАР

Нийгмийн хамгаалал, ходолморийн сайд

Т.ГАНДИ